



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.08.07 № 896  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Нийслэлийн Ард түмний хүч намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

2024 оны нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл /бие даан нэр дэвшигч/ нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцүүлэн боловсруулж санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит, Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа 2050", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль,

Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

### Дүгнэлт

Нийслэлийн Ард түмний хүч намын Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Нийслэлийн Ард түмний хүч намын сонгуулийн мөрийн хөтөлбөр /.....<sup>5</sup> хуудас/-ийг хавсаргав.

Хувийг Нийслэлийн Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ



Нийслэлийн Ард Түмний Хүч Намын  
Тэргүүлэгчдийн 2024 оны 06 дугаар сарын 21-ний  
өдрийн хуралдааны 01 дүгээр тогтоолоор батлав.

НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2024 ОНЫ  
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ НИЙСЛЭЛИЙН АРД ТҮМНИЙ ХҮЧ НАМЫН  
МӨРИЙН ХӨТӨЛБӨР



Нийслэлийн маань хүн бүр бие эрүүл, зохистой ажил хөдөлмөр эрхэлж, амьдралдаа хүрэлцэхүйц цалин-орлоготой, тохилог орон гэртэй, эрүүл, аюулгүй орчинд амар тайван амьдрах нөхцлийг бүрдүүлэх нь сонгуулийн мөрийн хөтөлбөрийн эрхэм зорилго мөн.

Манай нам иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны ээлжит сонгуульд нийгмийн хөгжлийн, эдийн засгийн хөгжлийн, шударга засаглал, аюулгүй байдлын, ногоон хөгжил, аюулгүй орчны бодлогын хүрээнд дараах хөтөлбөрийг сонгогчдодоо өргөн толилуулж байна.

**Нэг. Нийгмийн хөгжлийн бодлого.**

1.1. Бүрэн дунд боловсролын бодлого, үйл ажиллагаа нь суралцагсдыг эх газар нутаг, унаган байгалиа хайрлан хамгаалах, үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, ёс заншлаа хүндэтгэн дээдлэх, сурч мэдэх, хүнлэг энэрэнгүй, эх оронч монгол хүн, монгол улсын иргэн болгож төлөвшүүлэхэд чиглэнэ.

1.2. Боловсролын салбарт өмчийн хэвшил, нийслэл, аймгийн төв, сум орон нутгийн харъяаллаас хамаарсан ерөнхий боловсролын түвшний ялгаа гаргахгүй байх, хүүхдэд ээлтэй эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх, цэцэрлэг, сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд хүнс ханган нийлүүлэх нэгдсэн тогтолцоог нэвтрүүлж, хүүхдийг эрүүл баталгаат хоол хүнсээр хангах бодлого хэрэгжүүлнэ.


1.3. Гурваас зургаан насны хүүхдийг цэцэрлэгт бүрэн хамруулах, 1-3 насны хүүхдийг яслид асран өсгөх нөхцлийг бүрдүүлэх чиглэлээр шинэчлэл хийнэ.

1.4. Нийслэлийнхээ хүн амыг эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй, чирэгдэлгүй, төлбөрийн дарамтгүй оношилгоо, эмчилгээ, үйлчилгээнд хамруулж, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, нийтийн биеийн тамирыг хэвшүүлэх, эмийн аюулгүй байдлыг хангаж, эмийн үнийн дарамтаас хамгаалах, эрүүлжүүлж илааршуулах явдлыг эрүүл мэндийн салбарын тэргүүн зорилт болгоно.

1.5. Өрхийн болон дүүргийн нэгдсэн эмнэлэгийг орчин үеийн тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангаж, тэдгээрийг ажиллуулах эмч, мэргэжилтнүүдийг бодлогоор сургаж бэлтгэх, зайн оношлогоог нэвтрүүлэх, хүн бүрт эрүүл мэндийн үйлчилгээний дэвшилтэт ололтыг хямд хүртээж, эх орондоо найдвартай эмчлэгдэх нөхцлийг бүрдүүлэх бодлого баримтална.

1.6. Нийслэлийнхээ иргэдэд ажил, амьдралын эрүүл, аюулгүй орчин бүрдүүлж, агаар, хөрс, усны бохирдолтоос болж эрүүл мэндээр хохирогсдын шууд хохирлыг буруутай этгээдээр гаргуулах бодлого хэрэгжүүлнэ.

1.7. Эмнэлэг, боловсролын байгууллагын удирдлагыг улс төрөөс ангид байлгаж, эмч, багш, ажиллагсад амьжиргаандаа бүрэн хүрэлцэхүйц цалин хөлс авч, сэтгэл хангалуун



ажиллаж, амьдрах орон байрны таатай орчин бүрдэх нь салбарын бодлогын шинэчлэлийн бодит үр дүнгийн салшгүй нэгэн хэсэг байна.

1.8. Нийслэлийн гэр хороололын айл өрхийг боломжит шийдэл бүхий дулаан, цэвэр, бохирын шугамд холбох, био жорлон нэвтрүүлэх, шороон замыг хатуу хучилттай болгох, агаар дахь түлшний хор хөнөөлийг арилгах, гэр хорооллын дулаан халаалтыг дэвшилтэт технологи бүхий шөнийн дулаан хуримтлуурт цахилгаан халаагуураар шийдэх, коксжсон түлшний үйлдвэрлэлийг дэмжих, ахуйн хог хаягдлын менежментийг шинэчлэх замаар хөрсний бохирдол, агаарын бохирдол, тоосжилтыг багасгаж, улмаар инженерийн байгууламж бүхий амины орон сууцны хороолол бий болох нөхцөлийг бүрдүүлж иргэдийнхээ амьдралын чанарыг дээшлүүлнэ.

1.9. Химийн болон генийн өөрчлөлттэй хүнсний бүтээгдэхүүнийг илрүүлэх хүчин чадварыг бүрдүүлж, гаднаас оруулах, хэрэглэхийг хуулиар хориглох санаачлага гаргаж шийдвэрлүүлнэ.

1.10. Хүнсний аюулгүй байдлын стандартын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүний хэрэглээг дэмжиж, мөнхүү шаардлагад нийцсэн тээвэр, агуулахын сүлжээ, ложистик байгуулахыг дэмжинэ.

1.11. Монгол хүний хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэх, цагийн хөлсний хэлбэрийг жинхэнэ утгаар нэвтрүүлэх, дундаж орлоготой хэсгийг эрс нэмэгдүүлэх, орлого багатай хэсгийг тэтгэж дундаж орлоготны эгнээнд хүргэх бодлогыг хэрэгжүүлнэ.

1.12. Нийслэлийнхээ ард олны жижиг дунд бизнесийг жинхэнэ утгаар нь тэгш, шударгаар дэмжиж, энэ төрлийн зориулалттай тоног төхөөмжийн гаалийн татварыг хөнгөлөх, чөлөөлөх асуудлыг судлан шийдвэрлүүлж, тогтвортой, баталгаатай ажлын байрыг мэдэгдэхүйц нэмэгдүүлнэ.


1.13. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэд зэрэг нийгмийн зорилтот бүлгийг дэмжих бодлогыг бүтээлчээр үргэлжлүүлнэ.

1.14. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тогтолцооны шинэчлэлийг төгөлдөржүүлж, нийгмийн даатгалын шимтгэлийн ачааллыг хөнгөлөх, эрүүл мэндийн даатгалын өгөөжийг нэмэгдүүлэх асуудлыг судалж шийдвэрлүүлнэ.

1.15. Нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, газар зохион байгуулалтын төлөвлөгөөг цогцоор нь шинэчилж, ард түмэнд амьдрах орон гэрээ барих, бизнесийн болон мал аж ахуй, газар тариалан эрхлэх зориулалтаар газрыг жинхэнэ утгаар нь тэгш, шударгаар өмчлүүлэх, эзэмшүүлэх, үр ашгийг нь түргэн хүртэх газрын шинэтгэл, дахин хуваарилалтын бодлогыг хэрэгжүүлнэ.

1.16. Нийслэлийн гэр хороололд “Хашаандаа сайхан амьдаръя”, Жорлонгоо өөрчилъе” төслүүдийг хэрэгжүүлэх хөдөлгөөн өрнүүлж идэвхжүүлнэ.

1.17. Нийслэлийн төвлөрлийг задлах, хөгжлийг дэмжих зорилгоор төр захиргаа, мэдээлэл технологи, бизнес санхүү, соёл, боловсрол, шинжлэх ухаан, худалдаа үйлчилгээ, орон сууц, нийгмийн болон инженерийн дэд бүтцийн хангамж бүхий хотын шинэ төв, дэд төв, олон нийтийн төвүүдийг байгуулах бодлого хэрэгжүүлнэ.



A handwritten signature in black ink.





## Хоёр. Эдийн засгийн хөгжлийн бодлого.

2.1. Төсвийн хөрөнгө оруулалтыг үнэлэх, эрэмбэлэх, сонгох болон тендер сонгон шалгаруулалтын үйл явцыг олон нийтийн хяналтад оруулж, үр ашиг муутай барилга, байгууламж, хөшөө суварга барихад зарцуулж буй одоогийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн тогтолцоог эрс өөрчилж, төрийн захиргааны албаны нүсэр зардлыг эрс багасгах замаар нийслэл, дүүргийн төсвийн зардлын үр өгөөжийг бодитой нэмэгдүүлнэ.

2.2. Нийслэл, дүүрэгт эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгаалалд түлхүү чиглэсэн төсвийн бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

2.3. Татварын бодлогын эрх зүйн шинэчлэлийг төгөлдөржүүлж, нэмэгдсэн өртгийн албан татварын дарамтыг хөнгөлөх, өнгөрсөн 8 жилд шинээр бий болгосон, хувь хэмжээг нь нэмэгдүүлсэн татвар, хураамжийг буцааж байранд нь тавих, дундаас доош орлоготой иргэдийг орлогын албан татвараас чөлөөлөх, хэт өндөр орлоготой иргэдийн татварыг нэмэгдүүлэх бодлогын шинэчлэлийг судлан шийдвэрлүүлнэ.

2.4. Төрийн болон хувийн өмчийн монополь компаниудын өмч хөрөнгө, үйл ажиллагааг нь ард түмний хяналтад оруулах, өмч хөрөнгийн хэт төвлөрлийг задлах, нийгэмд өмч, орлогын тэгш байдал бүрдүүлэх бодлогын шинэчлэлийг дэмжинэ.

2.5. Төрийн албан тушаалын эрх мэдэл, төрийн хязгаарлагдмал мэдээллийг олзлон бизнесийн монополь тогтоодог явдлыг таслан зогсоож, эрх тэгш оролцоог хангасан бизнесийн хуваарилалтын бодлогын шинэчлэл хийнэ.

2.6. Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн хөгжлийн хүрсэн түвшинг ахиулж, салбарын ажиллагсадын хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй байдал, цалин хөлс, нийгмийн баталгааг хангаж хамгаалах бодлого хэрэгжүүлнэ.

2.7. Нийслэлийнхээ цахилгаан, дулааны эрчим хүчний өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг бүрэн хангах бодлого баримтална.


2.8. Нийслэл, дүүрэгт нийтийн тээврийн орчин үеийн шийдлийг нэвтрүүлэх, нийслэл, дүүгийн төв доторх авто зам дагуу ус зайлуулах сувагчлал байгуулах, шинэчлэх, гэр хорооллыг хатуу хучилттай авто замын сүлжээнд холбох бодлого хэрэгжүүлнэ.

2.9. Хүнс, барааны зах, худалдаа үйлчилгээний төвүүдийн дэд бүтэц, эрүүл ахуй, орчин нөхцөлийг сайжруулах бодлогын шинэчлэл хийнэ.

2.10. Дэвшилтэт технологи бүхий олон төрөл хэлбэрийн үйлдвэрлэл, технологийн паркууд, инновац, гарааны бизнес, оюуны үйлдвэрлэлийг дэмжих инновацийн төвүүдийг байгуулах бодлого хэрэгжүүлнэ.

2.11. Малын халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга, үйлчилгээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлээр олгож, малын эрүүлжүүлэлтийг олон улсын стандартад хүргэнэ.

2.12. Мал, малын гаралтай бүтээгдэхүүнийг шууд малчдын гараас худалдан авч, мах ноос, ноолуур, арьс шир, сүү, тос боловсруулах стандарт хангасан үйлдвэр, мах нөөцлөх зориулалт бүхий агуулах байгуулах, дотоодын мах нийлүүлэлтийн тогтолцоог шинэчлэх,



хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний биржийн худалдааг жинхэнэ утгаар нь хөгжүүлэх цогц бодлого хэрэгжүүлнэ.

2.13. Экспортод чиглэсэн өндөр ашиг шимтэй эрчимжсэн мал аж ахуйг газар тариалантай хослуулан хөгжүүлж, мал аж ахуйн таваарлаг чанарыг дээшлүүлэх, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхийг дэмжинэ.

2.14. Тариалангийн даатгалын тогтолцоог бүрдүүлэх, улаанбуудай, хүнсний ногооны импортын хэрэглээг хязгаарлах, тариалалт, хураалтыг улам бүр механикжуулах, автоматжуулах, агуулахын аж ахуй, усалгаатай газар тариаланг хөгжүүлэх, хөрсийг зохистой ашиглах, доройтлыг нөхөн сэргээх, үр тарианы талбайг хашаалж хамгаалах, төмс хүнсний ногооны зоорийг нэмэгдүүлэх замаар дотоодын хэрэглэгчдийн болон үрийн нөөцийн хэрэгцээг бүрэн хангаж улмаар экспортын боломжийг бүрдүүлэх бодлого хэрэгжүүлнэ.

### **Гурав. Шударга засаглал, аюулгүй байдлын бодлого.**

3.1. Ард түмнээ дээдлэх төрт ёсны уламжлал, шударга ёс, тэгш байдлыг тогтоох, хууль ёс дэг журмыг хангах, төрийн албаны сахилгыг эрс чангатгахад чиглэсэн улс төр, эрх зүйн бодлого хэрэгжүүлнэ.

3.2. Аливаа хууль, тогтоомж, шийдвэр нь төр, байгууллага, албан тушаалтны эрх ашгийг хамгаалсаар ирсэн тэгш бус бодлогыг халж, хууль, шийдвэр нь зөвхөн хүний сайн сайхны төлөө, хүнийг хамгаалахын төлөө байх бодлого хэрэгжүүлнэ.

3.3. Намын болоод амин хувийн зорилгоос ангид байж чадах өндөр мэдлэг, ур чадвар бүхий эх орон, ард түмний язгуур эрх ашгийг эрхэмлэгч, ноён нуруутай, хүнлэг, ёс зүйтэй, хүний эрхийн мэдрэмжтэй иргэдээр нийслэл, дүүргийн төрийн албыг бэхжүүлнэ.


3.4. Нийслэл, дүүргийн төр, захиргааны алба нь ард түмэнд ил тод, алагчлалгүй, шударга, хүртээмжтэй, хүнд сурталгүй үйлчилдэг, цомхон, ажил үүргийн давхцалгүй, мэргэшсэн, хариуцлагатай байх чиглэлээр эрс шинэчлэл хийнэ.

3.5. Нийслэл, дүүрэгт үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоог дахин хумиж, бүртгэлийн тогтолцоонд шилжүүлэх ажлыг төгөлдөржүүлж, энэ талаархи төрийн хүнд суртал, авилгыг таслан зогсооно.

3.6. Төрийн албаныханы төсвийн мөнгөөр тансаг оффис барьдаг, түрээсэлдэг, төрөл бүрийн өндөр үнэ хөлстэй үйлчилгээ авдаг, тансаг, хурд хүчтэй уналга хөсөг хэрэглэдэг байдлыг халж, удирдах албан тушаалтны тоог эрс цөөлөх бодлого явуулна.

3.7. Дээр доргүй өөрсдийн эрх ашигтаа нийцүүлэн хууль, тогтоомж, шийдвэр гаргаж баталдаг, засдаг явдлыг таслан зогсоох, энэ төрлийн үйлдэл, эс үйлдэл гаргагчдыг эрүүгийн хариуцлагад татах эрх зүйн орчин бүрдүүлэх асуудлаар хууль тогтоогчдод шахалт үзүүлж, нийслэл, дүүрэгт хуулиар олгогдсон эрх үүргийнхээ боломжит хүрээнд эхлэн хэрэгжүүлнэ.

3.8. Монгол орон, монгол хүний онцлог давуу талыг дэлхийн олон улсад сурталчлах орчин үеийн чиг хандлага бүхий үндэсний уламжлал бахархал шингээсэн аялал жуулчлалын дата баазыг нийслэлд байгуулах бодлогыг хэрэгжүүлнэ.





## **Дөрөв. Ногоон хөгжил, аюулгүй орчны бодлого.**

4.1. Цэвэр онгон байгалиа хойч үедээ өвлүүлэн үлдээх, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлэх, ард олон газар нутгаа зохистойгоор эзэмшиж, үр шимийг нь шударгаар хүртэх бодлого баримтлана.

4.2. Ойг түймэр, хөнөөлт шавьж, өвчин, хууль бус мод бэлтгэлээс хамгаалах, нөхөн сэргээх, ойн мэргэжлийн байгууллага, нөхөрлөл нэрийн дор арилжааны зорилгоор мод бэлтгэдэг хуульчлагдаж дархлагдсан хулгайчдын үйлдлийг таслан зогсоох, мод орлох технологийг нэвтрүүлэх, коксжсон түлшний үйлдвэрлэлийг дэмжих, нийслэл, дүүргийн төвийн ногоон байгууламжийг эрс нэмэгдүүлэх чиглэлээр бодлогын эрс шинэчлэл хийнэ.

4.3. Байгаль орчинд хохирол учруулсан талаархи бодитой мэдээлэлийг урамшуулах, хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй байгаль орчны бохирдол, доройтлыг хязгаарлан зогсоох чиглэлд шинэчлэл хийнэ.

4.4. Цөлжилтийг зогсоох, бэлчээрийн хэт талхагдлыг бууруулах, устах аюулд орж байгаа амьтан, ургамлаа хамгаалах ажлыг ард иргэдийнхээ санаачлага, дэлхийн хамтын нийгэмлэгийн дэмжлэгт тулгуурлан хийнэ.

4.5. Нийслэлийн агаарын бохирдлыг арилгах, хөрсийг эрүүлжүүлэх, хамгаалах, иргэдийн эрүүл, тав тухтай аюулгүй орчныг бүрдүүлэх хүрээнд хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх эрс шинэчлэлийн бодлого хэрэгжүүлнэ.

4.6. Аюултай болон барилгын хог хаягдлыг устгах, байршуулах зориулалтын байгууламж, цэг бий болгох, дахин боловсруулах үйлдвэр байгуулах, ахуйн хог хаягдал ангилах, ландфилийн аргаар булшлах, ландфиллын талбайд нөхөн сэргээлт хийх чиглэлээр бодлогын шинэчлэл явуулна.



--oOo--

